

**ӨМНӨГОВЬ АЙМАГ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН
МЭРГЭЖЛИЙН ХОЛБОО НИЙТИЙН ЭРХ ЗҮЙН
ХУУЛИЙН ЭТГЭЭДТЭЙ ХАМТРАН АЖИЛЛАХ САНАМЖ БИЧИГ**

2025 оны 05 сарын 11-ний өдөр

№: 25/13

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1.Энэхүү санамж бичгийг нэг талаас Өмнөговь аймгийн Засаг дарга, нөгөө талаас 8398801 регистрийн дугаартай “Аялал жуулчлалын мэргэжлийн холбоо” нийтийн эрх зүйн хуулийн этгээд, түүнийг төлөөлж ерөнхийлөгч Т.Баттулга (цаашид “Нийтийн эрх зүйн хуулийн этгээд” гэх), (хамтад нь цаашид “Талууд” гэх) нар нь дор дурдсан чиглэл, зарчмын хүрээнд хамтран ажиллахаар харилцан тохиролцож байгуулав.

ХОЁР. ЗОРИЛГО

2.1.Энэхүү санамж бичгийн зорилго нь талууд Монгол Улсад аялал жуулчлалын салбарыг бүсчилэн хөгжлүүлэх, Өмнөговь аймагт аялал жуулчлалын чиглэлээр тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх, аялал жуулчлалаар хүлээн авч буй жуулчдын болон оролцогчдийн оролцоог нэмэгдүүлэх, тэднийг чадавхжуулах, идэвхжүүлэхэд оршино.

2.2.Энэхүү санамж бичгийг хэрэгжүүлэхэд Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Монгол Улсын Их Хурлын 2024 оны 64 дүгээр тогтоолоор батлагдсан “Монгол улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал”, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Аялал жуулчлалын тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомж, тэдгээрт нийцүүлэн гаргасан эрх зүйн актыг тус тус баримтална.

ГУРАВ. ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ҮНДСЭН ЧИГЛЭЛ

3.1.Өмнөговь аймагт аялал жуулчлалын урсгалыг нэмэгдүүлэхтэй холбоотой санал, санаачилга гаргах, шаардлагатай мэдээлэл болон холбогдох эрх зүйн актын талаар мэдээлэл өгөх;

3.2.Аялал жуулчлалын тухай хуулийн 6.5, 10.1-д заасны дагуу Өмнөговь аймагт үйл ажиллагаагаа явуулж байгаа тур оператор, аяллын агентийн бүртгэлийн хөтлөхтэй холбоотой журмыг хэрэгжүүлэх;

3.3.Аялал жуулчлалын үйл ажиллагаатай эрхэлдэг иргэн, хуулийн этгээдийн хүний нөөцийг чадавхижуулах, хөгжүүлэх ажлын хүрээнд мэргэжлийн сургалтыг төрөлжүүлэн хамтран зохион байгуулах, шаардлагатай төрийн дэмжлэгийг үзүүлэхэд аялал жуулчлалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран ажиллах;

3.4.Өмнөговь аймгийн аялал жуулчлалын судалгаа, дата мэдээлэл, бүтээгдэхүүн үйлчилгээ, жуулчлалын статистик мэдээллийг өөрийн цахим хуудас, олон нийтийн сүлжээний сүлжээг сурталчлах;

3.5.Өмнөговь аймаг нь аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээг төрөлжүүлэн хөгжүүлэхтэй холбоотой санал, санаачилга, холбогдох судалгааг боловсруулах, хэрэгжүүлэх;

3.6.Говийн бүсийн брэнд бүтээгдэхүүн, эвент арга хэмжээг аялал жуулчлалын бүтээгдэхүүн болгох, аялал жуулчлалын эвент арга хэмжээний товыг өмнөх оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс өмнө гарган олон нийтэд мэдээлэх;

3.7.Байгаль орчин, эко аялал жуулчлалыг хөгжүүлэх, бүх нийтийн аялал жуулчлалын боловсрол олгох ажлын хүрээнд хамтран контент бүтээх;

3.8.Монгол Улсыг сурталчлах түлхүүр үг болох "Go Mongolia" "Go Mongolia Always Moving" өөрийн аймагт сурталчлах, хил орчмын болон бусад төрлийн аливаа аялал жуулчлалын үйл ажиллагаанд тогтмол хэрэглэх, сурталчлах;

3.9.Говийн бүсийн аялал жуулчлалыг хөгжүүлэхэд үр өгөөжтэй шинэ төсөл хөтөлбөрийг хамтран санаачилж, ерөнхий чиглэл, цар хүрээ, дэвшилтэт санаа, үр дүнгийн талаар санал мэдээлэл солилцож хамтран ажиллах;

3.10.Улсын болон орон нутгийн аялал жуулчлалын бүс, аялал жуулчлалын дэд бүтэц, отоглох цэг бий болгоход хамтран ажиллах.

ДӨРӨВ. АЖЛЫН УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ХАРИУЦЛАГА

4.1.Талууд энэхүү санамж бичгийн 3-т заасан чиглэлийг хэрэгжүүлэхдээ тухайлсан гэрээ байгуулах, мэдээлэл харилцан солилцох, шаардлагатай тохиолдолд ажлын хэсэг байгуулан ажиллаж болно.

4.2.Хамтын ажиллагааны явцад аль нэг талаас гомдол, хүсэлт гаргах нь санамж бичгийг цуцлах, хүчин төгөлдөр бус гэж тооцох үндэслэл болохгүй бөгөөд гомдол, хүсэлтийг үл маргах журмаар шийдвэрлэхийг талууд эрмэлзэнэ.

4.3.Талууд санамж бичгийн биелэлтийг тухайн жилийн 12 дугаар сард хэлэцэн дүгнэж цаашид хэрэгжүүлэх үйл ажиллагааг тодорхойлно.

ТАВ. БУСАД

5.1.Энэхүү санамж бичгийг талууд 3 (гурван) жилийн хугацаатай байгуулав.

5.2.Энэхүү санамж бичгийн хугацааг талууд харилцан тохиролцож сунгах бөгөөд талуудын удирдлага өөрчлөгдсөн нь санамж бичгийг цуцлах үндэслэл болохгүй.

5.3.Энэхүү санамж бичгийг Монгол хэл дээр 2 хувь үйлдсэн бөгөөд эх хувь тус бүр нэгэн адил хүчинтэй байна.

5.4.Энэхүү санамж бичиг байгуулсан нь талууд харилцан нөгөө талдаа эрх зүйн болон эдийн засаг, санхүүгийн үүрэг үүсэх үндэслэл болохгүй.

САНАМЖ БИЧИГ БАЙГУУЛСАН:



АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН МЭРГЭЖЛИЙН
ХОЛБОО НИЙТИЙН ЭРХ ЗҮЙН
ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН
ЕРӨНХИЙЛӨГЧ



Утас: 77128822, 99030928

Цахим шуудан: info@mto.mn